ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2019/66/СТА-ТШ3

Цахим хуудас: www.audit.mn

(Хотын нэр оруулах)

2019 он


Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 7052-2734, Цахим хаяг: dornogovi@audit.gov.com

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас: 7052-3020 Цахим хаяг: ...............................

Аудитор: Э.Вандандулам

Утас: 99058176 Цахим хаяг: mnbaudithhk@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1 Аудитын гэрчилгээ
2 Аудитын тайлан 5
2.1 Оршил .......... 5
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .......... 5
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .......... 6
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .......... 6
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .......... 7
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .......... 8
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .......... 8
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .......... 8
2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал…..9
2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .......... 10
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .......... 10
2.11. Шилэн дансны мэдээлэл .......... 11
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .......... 11
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .......... 11
3 Менежментийн захидал 12
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан 15

# 1 Аудитын гэрчилгээ

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019.03.04 № 1-6/267

танай_______________-ны №_______________-т

САЙНШАНД СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ
НЭГДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
С.ЗОРИГТ-ЭРДЭНЭ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 54.3, 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРУИНАА

# 2 Аудитын тайлан

## 2.1. Оршил

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирал С.Зоригт-Эрдэнэд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019-02-22-наас 2019-02-28–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019-03-01-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газартай гэрээ байгуулж ажиллаж байгаа Мөнгө Нөөц Баялаг Аудит ХХК-ны аудитор Э.Вандандулам хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн

аудитын газарт анх ирүүлсэн огноо 2019-02-22, дахин засварлаж ирүүлсэн 2019-02-28-нд ирүүлсэн бөгөөд 2019-01-25-ны өдрийн 11 дугаар бүхий албан бичгээр санхүүгийн тайлангийн аудит хийлгэх хүсэлт ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургууль нь Дорноговь аймгийн үлгэр жишээ болохуйц сургалтын болон сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлсэн, сурагч нэг бүрийг хөгжүүлж, үндэсний соёл уламжлалаа дээдэлсэн, зөв харилцаатай бүтээлч иргэнийг төлөвшүүлдэг эвсэг тэргүүний хамт олон болно гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрмээр Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.
- Ерөнхий боловсролын үйлчилгээ

- Боловсролын нэг буюу хэд хэдэн түвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлэх

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургууль дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургууль бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 0 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав. Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн үе шатанд суурь үзүүлэлтээр материалын түвшинг сонгосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 2018 оны нийт зардал 1,962,290.0 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 19,622.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь материаллагаас бага дүнтэй ажил гүйлгээ нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн шийдвэр гаргалтад нөлөөлөх нөлөөлөл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

### 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг B501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Зөвлөмж өгсөн | 2 | 4,489.30 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 2 | 4,827.30 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 1 | 1,364.90 | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| | Дүн | 5 | 10,681.50 | |

**2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Ажилчдаас ХХОАТ-ын суутгалыг буруу хийж 175,896.0 төгрөгийн авлага, 220,571.0 төгрөгийн өглөг үүсгэсэн мөн Татварын байгууллагад 839,706.0 төгрөгийг илүү, Нийгмийн даатгалын байгууллагад 105,756.0 төгрөгийг илүү шилжүүлж авлага үүсгэсэн нь төсвийн тухай хуулийн 6.4.1, 6.4.8, 39.4.2 заалтуудын төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, өр, авлага үүсгэхгүй ажиллах, тус хуулийн 7.7-д төсвийн жил дуусахад ... төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Ажилчдаас 220,571.0 төгрөгийг илүү суутгаж татварын албанд шилжүүлсэн тул 724,891.0 (839,706.0+105,756.0-220,571.0) төгрөгийг татварын байгууллага болон Нийгмийн даатгалын байгууллагад тайлант хугацааны зардлаас илүү шилжүүлсэн гэж үзэж байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u>Төлбөрийн акт тогтоож, биелэлтийг 2019 оны 3 дугаар сарын 25-ны дотор Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт ирүүлэх

2. 2017-12-31-ээрх санхүүгийн тайланд тусгагдсан 1364.9 мянган төгрөгийн авлагын барагдуулж ажиллаагүй нь төсвийн тухай хуулийн 6.4.1, 6.4.8, 39.4.2 заалтуудын төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, өр, авлага

үүсгэхгүй ажиллах заалтыг зөрчиж, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1 заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгч, биелэлтийг 2019 оны 6 дугаар сарын 20-ны дотор Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт ирүүлэх

3. Дорноговь аймгийн ахмад багш нарын холбооны дансанд 4,102,496.0 төгрөгийг шилжүүлсэн нь ахмад настны тухай хуулийн 4.1.2, 14.7, Засгийн Газрын 2017 оны 197 тоот тогтоолын "Ахмадын сан ажиллуулах журам"-ын 1.2 заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоож, биелэлтийг 2019 оны 4 дугаар сарын 25-ны дотор Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт ирүүлэх талаар заасан боловч үйлчлүүлэгч байгууллага “Дорноговь аймгийн Ахмад багш нарын холбооны дарга Л.Хоролсүрэн нь тус сургуулийн ахмад багш бөгөөд сургуулийн ахмад багш нар тус дансаар дамжуулан үйл ажиллагаагаа явуулдаг тул актыг хүлээн зөвшөөрөхгүй байна.” гэсэн тайлбар өгсөн тул **дараагийн шатны хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх шаардлагатай** гэж үзлээ.

### 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байгууллагын бүтэц орон тоо, цалингийн тооцоолол, тайлагнал, санхүүжилтийг зориулалтын дагуу эдийн засгийн ангилалын дагуу зарцуулж байгаа эсэх,

Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрч байгаа эчнээ ангийн төлбөр, төвлөрүүлэлт

### 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургууль чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 11 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,820,724.3 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,818,210.5 мянган төгрөг буюу 99,8 хувьтай байгаа нь Цалин хөлс болон нэмэгдэл урамшил -600.7 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал -1,438,200. Хангамж, бараа материалын зардал 334,354.5 Нормативт зардал -520,060.0 Эд хогшил, урсгал засварын зардал -77,382.0, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж -2,250.0 гэх мэт зардлаас төгрөг хэмнэснээс шалтгаалжээ.

### 2.11. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд Ингүүмэл жаргалант аудит ХХК аудит хийсэн бөгөөд 1 төлбөрийн акт тогтоож, 7 зөвлөмж өгснөөс Гоц Медиа ХХК-аас авах авлагыг барагдуулаагүй ажиллаж 85%-тай биелэсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### 2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургууль 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

# 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургууль нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

## 1. ОРЛОГО, ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

**Илрүүлэлт**

1. Их засварын ажил хийж байгаатай холбоотой хуучин цонхнуудыг өмч хамгаалах зөвлөлийн хурлаар үнэ тогтоож борлуулж нэмэлт санхүүжилтийн дансанд 1440,0 мянган төгрөгийн цонхны үнэ төвлөрүүлсэн бөгөөд бараа материалд бүртгээгүй шууд борлуулалт хийсэн нь нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрөх орлого шамшигдах эрсдэл үүсгэхээс гадна УСНББОУС-12-ын 9-11 заалтыг зөрчиж байна.
2. Эцэг эх болон бусад холбоотой талаас хандивласан хөрөнгийг бүртгэж, санхүүгийн тайланд тусгаагүй, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 25.7 заалт, УСНББОУС 23-ийн 93-103 хэсгийг зөрчсөн байна.
3. Нэмэлт санхүүжилтийн данснаас шүүхийн шийдвэрээр олгогдсон 5021.1 төгрөгийн цалингийн нөхөн олговороос НДШ, ХХОАТ-ыг тооцож суутгаагүй олгосон нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32.1.1 заалт, ХХОАТ-ын тухай хуулийн 23.1 заалтыг тус тус зөрчсөн байна.

**Эрсдэл**

Төсөвт байгууллагын хөрөнгө, нэмэлт орлогыг дутуу бүртгэх

**Зөвлөмж**

Худалдан борлуулах зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгийг бүртгэлд тусгах, эцэг эх бусад холбоотой талаас хандивласан хөрөнгийг бүртгэлд тусгаж, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх, ажиллаагүй хугацааны цалингаас НДШ, ХХОАТ суутгаж холбогдох байгууллагад тайлагнах.

**Хариуцах ажилтан**

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн захирал С.Зоригт-Эрдэнэ

**Төсвийн захирагчийн хариу**

Төсвийн тухай хууль болон УСНББОУС-уудыг мөрдөж ажиллана. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн тогтоолд НДШ, ХАОАТ-ын суутгалын талаар дурдаагүй байсан тул суутгалыг тооцож шилжүүлээгүй.

Дээрх тайлбарыг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 28-ний өдөр баталгаажуулж ирүүлсэн.

## НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ДАНСНЫ ҮЛДЭГДЭЛ, ГҮЙЛГЭЭГ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТОДРУУЛГАД ЗӨРҮҮТЭЙ ТУСГАГДСАН БАЙХ

**Илрүүлэлт**

1. 2018 оны хагас жилийн тооллогын комиссын дүгнэлтэд тусгагдсан 4489,3 мянган төгрөгийн анхны өртөг бүхий дутагдсан үндсэн хөрөнгө санхүүгийн тайланд тусгагдаж уг дансны үлдэгдэл буруу илэрхийлэгдсэн байхаас гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6, 12.4 заалтуудыг зөрчсөн байна.

**Эрсдэл**

Төсөвт байгууллагын хөрөнгө илүү дутуу илэрхийлэгдэх

**Зөвлөмж**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6, 12.4 заалтуудыг хэрэгжүүлж холбогдох хууль дүрэм журмын дагуу шийдвэрлэх

**Хариуцах ажилтан**

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн захирал С.Зоригт-Эрдэнэ

**Төсвийн захирагчийн хариу**

Холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангаж ажиллана.

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 2 дугаар сарын 28-ний өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6-р сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Ч.АРИУНАА

АУДИТЫН МЕНЕЖЕР: Ц.ЛҮНДЭГМАА

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР: Э.ВАНДАНДУЛАМ

# 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **91,095,081.89** | **204,219,226.26** |
| **33** | **АВЛАГА** | 7,235,626.71 | 123,290,044.77 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 2,646,000.00 | 281,652.48 |
| **335** | **Бусад авлага** | 4,589,626.71 | 123,008,392.29 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 4,589,626.71 | 123,008,392.29 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 83,859,455.18 | 80,929,181.49 |
| **351** | **Түүхий эд материал** | 122,770.00 | 66,030.00 |
| 35130 | Эм боох материал | 122,770.00 | 66,030.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 80,006,685.18 | 75,898,151.49 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 899,064.00 | 1,180,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 20,230,546.68 | 11,977,057.68 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 3,630,315.01 | 599,500.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 112,542.50 | 00.00 |
| 35460 | Хүнсний материал | 3,353,302.00 | 3,954,640.50 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 51,780,914.99 | 58,186,453.31 |
| 35600 | Мал амьтад | 3,730,000.00 | 4,965,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,930,248,306.21** | **6,867,314,727.16** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,930,248,306.21 | 6,867,314,727.16 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,930,248,306.21 | 6,386,738,727.16 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 5,171,447,519.00 | 5,915,931,218.49 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -2,374,564,641.18 | 00.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 420,572,660.49 | 479,360,384.49 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -347,068,328.97 | -375,315,435.28 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 157,958,740.98 | 216,345,275.98 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -110,756,089.63 | -120,564,622.17 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 5,539,000.00 | 141,613,216.65 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -2,504,183.48 | -34,300.00 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 00.00 | 119,268,360.00 |
| 39217 | Ном | 9,623,629.00 | 10,134,629.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 00.00 | 480,576,000.00 |
| 39301 | Програм хангамж | 3,004,320.00 | 3,004,320.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -3,004,320.00 | -3,004,320.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 00.00 | 480,576,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,021,343,388.10** | **7,071,533,953.42** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **5,106,223.12** | **220,571.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 5,106,223.12 | 220,571.00 |
| **413** | **Өглөг** | 5,106,223.12 | 220,571.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 5,106,223.12 | 220,571.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,016,237,164.98** | **7,071,313,382.42** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,016,237,164.98 | 7,071,313,382.42 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,105,263,319.33 | 1,585,839,319.33 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,105,263,319.33 | 1,585,839,319.33 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -871,676,270.35 | -791,610,971.71 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -871,676,270.35 | -854,960,290.35 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 63,349,318.64 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,782,650,116.00 | 6,277,085,034.80 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,021,343,388.10** | **7,071,533,953.42** |

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,552,985,549.00** | **2,025,639,371.32** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **27,124,249.00** | **178,744,985.32** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 21,322,589.00 | 178,744,985.32 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 21,322,589.00 | 59,620,598.32 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 10,122,589.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 11,200,000.00 | 59,620,598.32 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 119,124,387.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 5,801,660.00 | 00.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 5,801,660.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **00.00** | **26,170,086.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,525,861,300.00 | 1,820,724,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 26,170,086.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 19,330,300.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 6,839,786.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,767,622,871.96** | **1,835,031,721.48** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,767,622,871.96** | **1,835,031,721.48** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,555,606,059.16 | 1,591,885,834.27 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 831,687,962.69 | 931,794,735.71 |
| 210101 | Үндсэн цалин | 483,388,545.00 | 646,036,619.71 |
| 210102 | Нэмэгдэл | 303,299,417.69 | 202,746,808.00 |
| 210104 | Урамшуулал | 45,000,000.00 | 83,011,308.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 90,728,616.00 | 113,827,818.40 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 90,728,616.00 | 85,828,646.56 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 6,999,591.71 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 5,600,173.37 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 1,400,021.34 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 13,999,385.42 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 288,050,657.00 | 281,452,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,102,121.00 | 7,315,184.00 |
| 210302 | Түлш, халаалт | 234,485,180.00 | 246,211,504.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 44,463,356.00 | 27,925,512.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 24,400,112.10 | 25,480,951.01 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,505,150.00 | 1,269,817.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 34,800.00 | 100,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,717,619.10 | 859,936.50 |
| 210404 | Ном, хэвлэл | 26,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 509,000.00 | 282,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 19,607,543.00 | 4,343,360.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 18,625,837.51 |
| **2105** | **Нормативт зардал** | 60,455,472.50 | 58,011,941.50 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 956,740.00 | 626,890.00 |
| 210502 | Хоол, хүнс | 58,871,894.50 | 57,385,051.50 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 626,838.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 25,934,336.50 | 10,357,017.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,400,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 20,534,336.50 | 10,357,017.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 700,000.00 | 1,000,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 700,000.00 | 1,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,730,650.00 | 1,440,110.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,730,650.00 | 1,440,110.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 229,918,252.37 | 168,521,060.65 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,448,360.00 | 4,548,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 15,037,584.00 | 14,322,075.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 213,432,308.37 | 149,650,985.65 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 212,016,812.80 | 243,145,887.21 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 00.00 | 123,441,937.21 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 00.00 | 123,441,937.21 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 212,013,920.00 | 119,703,950.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 69,949,720.00 | 74,965,650.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 18,764,800.00 | 18,863,500.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 96,245,400.00 | 25,874,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 27,054,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,892.80 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,892.80 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-214,637,322.96** | **190,607,649.84** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 545,544.27 | 127,258,331.20 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 545,544.27 | 00.00 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 00.00 | 127,258,331.20 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -545,544.27 | -127,258,331.20 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-215,182,867.23** | **63,349,318.64** |

## 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,535,983,889.00** | **1,964,214,987.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **10,122,589.00** | **119,124,387.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 10,122,589.00 | 119,124,387.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 10,122,589.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 10,122,589.00 | 00.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 119,124,387.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,525,861,300.00** | **1,845,090,600.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,525,861,300.00 | 1,820,724,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 24,366,300.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 19,330,300.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 5,036,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,525,471,889.00** | **1,907,615,043.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,525,471,889.00** | **1,907,615,043.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,306,823,096.20** | **1,665,756,155.79** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 824,044,245.00 | 932,941,813.29 |
| 210101 | Үндсэн цалин | 483,388,545.00 | 565,301,013.00 |
| 210102 | Нэмэгдэл | 295,655,700.00 | 278,988,900.29 |
| 210104 | Урамшуулал | 45,000,000.00 | 88,651,900.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 88,929,300.00 | 112,823,300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 88,929,300.00 | 81,248,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 7,893,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 6,315,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 1,578,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 15,787,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 272,189,078.60 | 281,452,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,102,121.00 | 7,315,184.00 |
| 210302 | Түлш, халаалт | 218,623,601.60 | 246,211,504.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 44,463,356.00 | 27,925,512.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 22,380,119.10 | 4,780,554.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 800,000.00 | 639,140.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 100,000.00 | 100,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,962,519.10 | 859,936.50 |
| 210404 | Ном, хэвлэл | 175,100.00 | 50,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 582,000.00 | 282,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 18,760,500.00 | 2,849,478.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 51,433,998.00 | 70,732,940.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 794,360.00 | 530,150.00 |
| 210502 | Хоол, хүнс | 49,754,800.00 | 59,302,790.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 884,838.00 | 10,900,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 26,599,166.50 | 249,117,074.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,400,000.00 | 3,804,256.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 1,500,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 639,877.00 |
| 210604 | Урсгал засвар | 21,199,166.50 | 243,172,941.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 700,000.00 | 1,000,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 700,000.00 | 1,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,901,900.00 | 1,848,550.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,901,900.00 | 1,848,550.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 16,645,289.00 | 11,059,724.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 750,000.00 | 1,899,762.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 15,895,289.00 | 9,159,962.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **218,648,792.80** | **241,858,887.21** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 00.00 | 123,441,937.21 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 00.00 | 123,441,937.21 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 218,645,900.00 | 118,416,950.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 73,935,700.00 | 73,678,650.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 18,764,800.00 | 18,863,500.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 96,245,400.00 | 25,874,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 29,700,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,892.80 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,892.80 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **10,512,000.00** | **56,599,944.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **10,512,000.00** | **56,599,944.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **10,512,000.00** | **56,599,944.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 10,512,000.00 | 56,599,944.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 10,512,000.00 | 56,599,944.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-10,512,000.00** | **-56,599,944.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,105,263,319.33 | 2,782,650,116.00 | -656,493,403.12 | 00.00 | 3,231,420,032.21 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,105,263,319.33** | **2,782,650,116.00** | **-656,493,403.12** | **00.00** | 3,231,420,032.21 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -215,182,867.23 | 00.00 | -215,182,867.23 |
| C08 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,105,263,319.33** | **2,782,650,116.00** | **-871,676,270.35** | **00.00** | 3,016,237,164.98 |
| D01 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,105,263,319.33** | **2,782,650,116.00** | **-871,676,270.35** | **00.00** | 3,016,237,164.98 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 16,715,980.00 | 00.00 | 16,715,980.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,105,263,319.33** | **2,782,650,116.00** | **-854,960,290.35** | **00.00** | 3,032,953,144.98 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,  бууралт | 00.00 | 3,494,434,918.80 | 00.00 | 00.00 | 3,494,434,918.80 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 480,576,000.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 480,576,000.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 63,349,318.64 | 00.00 | 63,349,318.64 |
| D09 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,585,839,319.33** | **6,277,085,034.80** | **-791,610,971.71** | **00.00** | 7,071,313,382.42 |

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,820,724,300.00 | 1,818,210,535.79 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,820,724,300.00 | 1,818,210,535.79 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,701,498,000.00 | 1,699,793,585.79 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 920,094,700.00 | 920,094,099.29 |
| 210101 | Үндсэн цалин | 553,995,100.00 | 553,870,713.00 |
| 210102 | Нэмэгдэл | 277,447,700.00 | 277,571,486.29 |
| 210104 | Урамшуулал | 88,651,900.00 | 88,651,900.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 112,823,300.00 | 112,823,300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 77,519,200.00 | 81,248,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,434,200.00 | 7,893,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,452,700.00 | 6,315,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,765,200.00 | 1,578,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,652,000.00 | 15,787,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 282,890,400.00 | 281,452,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,404,500.00 | 7,315,184.00 |
| 210302 | Түлш, халаалт | 246,338,500.00 | 246,211,504.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 29,147,400.00 | 27,925,512.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,957,200.00 | 5,291,554.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 800,000.00 | 639,140.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 100,000.00 | 100,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 361,400.00 | 859,936.50 |
| 210404 | Ном, хэвлэл | 564,000.00 | 539,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 282,000.00 | 282,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,849,800.00 | 2,870,578.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 64,793,000.00 | 64,272,940.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,050,000.00 | 530,150.00 |
| 210502 | Хоол, хүнс | 52,843,000.00 | 52,842,790.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,900,000.00 | 10,900,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 301,688,600.00 | 301,611,218.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 10,000,000.00 | 10,000,000.00 |
| 210602 | Тавилга | 43,600,000.00 | 43,565,200.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,058,000.00 | 2,697,877.00 |
| 210604 | Урсгал засвар | 246,030,600.00 | 245,348,141.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,850,800.00 | 1,848,550.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,850,800.00 | 1,848,550.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11400000.00 | 11399724.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,900,000.00 | 1,899,762.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,500,000.00 | 9,499,962.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 119226300.00 | 118416950.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 119,226,300.00 | 118,416,950.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 74,488,000.00 | 73,678,650.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 18,863,500.00 | 18,863,500.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 25,874,800.00 | 25,874,800.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 00.00 | 1,820,724,300.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 00.00 | 1,820,724,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 00.00 | 1,820,724,300.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 99.00 | 99.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 71.00 | 71.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 27.00 | 27.00 |